



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: Олон Улсын Улаанбаатарын их сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэлний орчуулга (солонгос хэл )

Индекс: D023101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д. Эрдэнэсүрэн

Гишүүд: Н. Мэнд

Г. Энхжаргал

Он сар өдөр: 2019. 03. 22

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

**VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
ОУУБИС	Олон Улсын Улаанбаатарын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Олон Улсын Улаанбаатарын их сургууль International University of Ulaanbaatar	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга (солонгос хэл) Korean translation	
<b>Индекс</b>	D023101	
<b>Шинжээчид</b>	Ахлагч: Д. Эрдэнэсүрэн- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Хэл соёлын сургуулийн багш Гишүүд: Н. Мэнд-ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г. Энхжаргал -МУБИС, Багшийн сургуулийн багш	
<b>БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн</b>	Б. Оюунчимэг, Н. Түмэнжаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019.02.28	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хүлээн авч, БМИҮЗ-тэй гэрээ байгуулсан.
	2019.03.07	Загварын дагуу урьдчилсан үнэлгээний тайлан гаргаж, сургуулиас лавлах тодруулах асуудлуудыг гаргасан
	2019.03.11-12	Сургууль дээр очиж өөрийн үнэлгээний тайлангийн дагуу лавлах, тодруулах, баримт нотолгоотой танилцсан
	2019.03.22	Өөрийн үнэлгээний тайланг ажлын албанд өгсөн
	2019.03.29	Сургуулиас ирүүлсэн санал, тайлбарыг нягталж, үнэлгээний тайланг эцсийн байдлаар бичиж ажлын албанд хүлээлгэж өгсөн
	4 сарын эхээр	Мэргэжлийн зөвлөлд танилцуулах
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага, холбогдох дүрэм журам	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ОУУБИС нь 1995 онд БНСУ-ын хөрөнгө оруулалттай сургууль байгуулж, Солонгос хэлний багш, орчуулагчийн анги нээж, 1999 оноос анхны мэргэжилтнүүдийг төгсгөн гаргасан. Тус хөтөлбөрийг 23 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа.

Өнгөрсөн хугацаанд 920 мэргэжилтэнг бэлтгэн гаргасан бөгөөд уг хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид нь дотоод гадаадын компани, аж ахуйн нэгжид мэргэжлээрээ ажиллаж байна. Сүүлийн 5 жилд 2014-2019 онд уг хөтөлбөрөөр суралцагчдын тоо 225 оюутан, багшийн тоо 9 байна. Мөн сүүлийн 5 жилд хөтөлбөрөөр суралцагчдаас 87 нь тэтгэлэгт (мөнгөн дүн: 33, 676,000 төгрөг ) хамрагджээ. 2015-2018 онд төгсөгдчийн 18.8 хувь нь БНСУ-ын их дээд сургуулиудад ахисан шатны сургалтад үргэлжлүүлэн сурч байна.

Гадаад хэлний (Солонгос хэлний орчуулга) хөтөлбөрийн зорилго нь солонгос хэл, түүх, соёл, заншил, сэтгэлгээний талаар тодорхой мэдлэгийг олгож, солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын дээд түвшний мэдлэг чадварыг эзэмшүүлж, монгол солонгос хэлээр бүх салбарт бичгийн орчуулга болон хэлмэрчлэл хийх чадвартай мэргэжилтэн бэлтгэж, Монгол улсын хөгжил дэвшилд шаардлагатай, эдийн засаг нийгмийн хэрэгцээнд нийцсэн, олон улсын түвшний мэдлэг боловсрол эзэмшсэн, хөрвөх чадвартай боловсон хүчний бэлтгэхэд оршино гэж тодорхойлжээ.

Гадаад хэлний орчуулга хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадварыг дараах байдлаар тодорхойлсон байна.

“Солонгос хэлээр энгийн болон албан харилцаанд ямар ч сэдвийн хүрээнд чөлөөтэй ярьж, бичдэг, солонгос хэлний түвшин тогтоох (ТОPIK) шалгалтын дундаас дээш шатны мэдлэгтэй, багаар ажиллах сэтгэлгээний эерэг хандлагатай, харилцааны соёл, ур чадварыг эзэмшсэн, мэргэжлийн өндөр чадвартай орчуулагчийг бэлтгэнэ” гэжээ.

Гадаад хэлний орчуулга (солонгос хэл) хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 123 багц цагаар төлөвлөсөн ба Ерөнхий суурь хичээл-36 кр буюу 29,2 хувь, Мэргэжлийн суурь хичээл-31 кр буюу 25,2 хувь, мэргэжлийн хичээл-52 кр буюу 42,2 хувь, дадлага 4 кр-ийг эзэлж байна.

Анх удаа БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлж байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

-Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/

-Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Монголын нийгэм, эдийн засгийн хөгжилд тухайн хөтөлбөрийн оруулж буй хувь нэмэр, ирээдүйн төлөвт дүн шинжилгээ хийдэг.

### **Анхаарах асуудал:**

- Гадаад орнуудын ижил хөтөлбөрт анализ хийж харьцуулалт гаргасан ч бусад хөтөлбөрүүдийн давуу талуудыг өөрийн хөтөлбөрт хэрхэн сайжруулалт хийсэн нь тодорхойгүй.

### **Зөвлөмж:**

- Ажил олгогч, төгсөгчдийн эрэлт хэрэгцээний судалгааг цаашид байнга тогтмолжуулах
- Цаашид хөтөлбөрөөр төгсөж буй мэргэжилтний хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагыг олон улсын чиг хандлагыг харгалзаж тооцоолох шаардлагатай.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлж, түүнд нийцсэн мэргэжлийн ур чадварыг олгож байгаа. Шинэчилсэн хөтөлбөрийг дэд, ерөнхий хороогоор хэлэлцүүлж, эрдмийн зөвлөлөөр батлуулан тэнхимд мэдэгдэж, суралцагч, эцэг эхчүүдэд зөвлөх багш болон сургуулийн сайтаар дамжуулан хүргэдэг.

### **Зөвлөмж:**

- Цаашид хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ төгсөгчийн загвар боловсруулж шинэчлэл хийдэг байх.

## **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулж ирсэн.
- 2018 оны хөтөлбөрт суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулгыг CDIO аргад тулгуурлан боловсруулсан.
- Хөтөлбөрийг дэд хороо болон ерөнхий хороогоор хэлэлцүүлж, Эрдмийн зөвлөл баталдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтад хэрэглэх аргууд болон сургалтын ерөнхий арга зүй болох CDIO-ийн холбоо хамаарлыг хичээлийн хөтөлбөрт уялдуулаагүй байна.
- 2017 онд боловсруулсан сургалтын хөтөлбөр боловсруулах загварт хичээлээр эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга зүйн томъёолол дутмаг байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга зүйг боловсруулж хэрэглэх
- CDIO-ийн холбоо хамаарлыг хичээлийн хөтөлбөрт уялдуулах

#### **1- р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **1- р шалгуурын дүгнэлт**

- **Хөтөлбөрийн төлөвлөлт хэсэгт гадаад дотоод хүчин зүйлсийг тооцоолж, Swot шинжилгээ хийн TOWS матрицийг гаргасан.**
- **Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг Монгол улсын гадаад харилцаа, БНСУ-аас Монгол улсад оруулж буй хөрөнгө оруулалт, зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн тооцоолсон**
- **2017 онд ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг МУИС, ХИС-ийн хөтөлбөр, гадаадаас Турз улсын Анкара их сургууль, Кампуч улсын Пномпин их сургуулийн хөтөлбөртэй харьцуулан, анализ хийжээ.**
- **Хөтөлбөрийн зорилгыг сургуулийн зорилго зорилттой уялдуулан хөтөлбөрийн төлөвлөлт хийж хөтөлбөрийн бичиг баримтаа боловсруулж байна.**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

-Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц

- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2018 онд тэнхимийн хурлаар мэргэжлийн хичээлүүдийн цогц чадамжийн талаар хэлэлцэж, төгсөх ангийн 15 оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа авч, дүн шинжилгээ хийснээр сургалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, “Бизнес, эдийн засгийн орчуулга” хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг томъёолж, 2014 оноос эхлэн хөтөлбөрийн шинэчлэлд ажил олгогч, оюутан, төгсөгчдийн саналыг тусгаж, “Бизнесийн солонгос хэл” хичээлийг 2018 оны сургалтын төлөвлөгөөнд тусгаснаас гадна төгсөгчдөөс авсан судалгааны үр дүнд тулгуурлан 2018 оноос “Статистикийн үндэс” хичээлийг судлуулж байгаа зэрэг сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган 2011, 2013, 2014, 2016, 2018 онуудад тус тус шинэчлэн боловсруулсан.
- 2015 оноос хичээл сонголтыг оюутан өөрөө судлах хичээл, багшаа сонгож, хичээлийн хуваариа зохиодог.
- Мэргэжлийн хичээлүүдийн залгамж холбоог харуулсан матриц гаргаж ажиллаж байна.
- Солонгос улстай хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэний үр дүнд е-сургалтыг 2012-2015 онуудад нэвтрүүлж, хөгжүүлж ирсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын төлөвлөгөө болон хичээлүүдийн хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын уялдаа холбоог харуулсан матрицыг эргэж харах, дүн шинжилгээ хийх
- 2011, 2013, 2014, 2016, 2018 онуудад тус тус шинэчлэн боловсруулсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлтүүдийг тухайн цаг үеийн боловсролын бодлогын хэрэгжилтийг биелүүлэхэд чиглэн боловсруулж батлуулсан гэж тайланд тусгасан байна. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг “Гадаад хэлний орчуулга” мэргэжлээр суралцаж буй мэргэжлийн мэдлэг, чадвар хандлагын эзэмшилтэд, сургалтын чанарт дүн шинжилгээ хийж, сайжруулах, чанарын баталгаажуулалт хийх зорилгоор оюутан, багш, ажил олгогч, төгсөгчид, сонирхогч талуудтай хамтран

судалгаа хийсний үндсэн дээр үр дүнд суурилан өөрчлөлт оруулж, шинэчлэн сайжруулж буй байдалдаа дүн шинжилгээ хийх,

- Аман болон бичгийн орчуулга хийх дадлагын чанарт хийсэн дүн шинжилгээ, ажил олгогч, сонирхогч талуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ үр дүнг хөтөлбөрт тусгагдсан байдал дутмаг
- Оюутны сургалтын ажилд зарцуулж буй цагийн ачааллын судалгаа хийгдээгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Суралцахуйн үр дүнгийн матрицыг нэгж хичээлийн мэдлэг, чадвар, хандлага гэж томъёолсон тохиолдолд үр дүнгээ үнэлэх боломжыг хэрхэн харж байгаа талаар дүн шинжилгээ хийх
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтуудыг хийхдээ оюутан хичээл заах багшийн туршлага, арга зүй, хичээлийн хэлбэр, зохион байгуулалтын онцлог зэрэг мэдээллийг танилцуулга хэлбэрээр оюутанд нээлттэй хүргэж сонгуулдаг байхад чиглэн ажиллах
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулахдаа дан хичээлүүдийн код биш нэрсийг бичиж графикийг сайжруулах
- Суралцагчийн цагийн ачааллын судалгааг курс бүрээр гаргаж, бие даалтын ажилд зарцуулах цагийг үйлийн судалгаа хийн нарийвчлан тусгаж өгөх

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

-Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж

-Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2018 онд шинэчилсэн хөтөлбөрийн ерөнхий арга зүйг CDIO байхаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа бөгөөд ОУУБИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий Хорооны 2017.10.04-ний өдрийн шийдвэрээр “Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах загвар”-ыг баталж, зөвлөмж болгон гаргасан.
- 2017 онд 117 оюутнаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар багшийн ур чадварыг үнэлэх зорилгоор судалгаа авч, үр дүнг боловсруулсан.
- Зарим багш нарын хувьд хичээлийн хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийг томъёолж харьцуулсан судалгаа хийсэн байна.



### **Анхаарах асуудал:**

- CDIO сургалтын арга зүйг хэрэгжүүлэхэд чиглэсэн 8 үндсэн сургалтын арга зүйг чухалчилахаас гадна “солонгос хэлний дүрэм заах аргаар”, “онлайн”, мобайл, холимог арга зүйг ашиглан хэл шинжлэлийн хичээлүүдийг явуулж байгаа тухай дурдсан байна. Эдгээр аргууд нь сургалтын ерөнхий арга зүй болох CDIO-г хэрэгжүүлэхэд хэрхэн чиглэгдэж байгаа талаар багш нарын ойлголт дутмаг байна.
- Оюутнаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд багшийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй арга зүйн хэрэгжилт, үр дүнг үнэлэх нарийвчилсан асуулга байхгүй, 1-5 оноогоор үнэлэхээр тусгагдсан нь чанарын үнэлгээ хийх боломжгүй, хэт ерөнхийлсөн асуулга байж болзошгүй байна.
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал дутмаг байна.

### **Зөвлөмж:**

- “Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах загвар” буюу зөвлөмжийн хүртээмжтэй байдалд анхаарч, нийт багш нарын дунд хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, сургалтын ерөнхий арга зүй болох CDIO-г хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох төлөвлөгөөт үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаа хариуцсан албад, тэнхимтэй хамтран хэрэгжүүлж, үнэлгээ хийх

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

-Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, рубрик арга г.м/

-Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/

-Явцын болон төгсөлтийн шалгалтын журам

-Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Явцын (4-р улирал) болон төгсөлтийн (7 эсвэл 8-р улирлын төгсгөлд) шалгалтыг 3 үе шаттай зохион байгуулахаас гадна оюутнууд солонгос хэлний түвшин тогтоох шалгалт өгч, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх (ТОPIK 1,2) боломжтой.
- Суралцагчийн сурлагын амжилт, чанарын судалгааг 2014-2015 оны хичээлийн жилээс хийж хэвшсэн бөгөөд дүн шинжилгээ хийж ажиллаж байгаа сайн туршлага харагдаж байна.
- Шалгалтын журам батлагдан хэрэгждэг.

- Суралцагчийн сурлагын амжилтад, дүнгийн чанарт дүн шинжилгээ хийж сурлагын амжилт, чанарыг үнэлэн ажилладаг сайн туршлага бий болсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж буй үнэлгээний арга зүйн судалгаа өөрийн үнэлгээний тайлан болон багш нарын хөтөлбөрт хийж буй дүн шинжилгээ, хөтөлбөрийн хавтас зэрэгт харагдахгүй байна.
- Оюутнаас авч буй шалгалтын, тестийн боловсруулалт, гүйцэтгэлд баталгаат чанарын үнэлгээ хийсэн байдал, хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ дутмаг байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгааг Блум таксономи, Marzano таксономи, Рубрик арга зэрэг үнэлгээний арга зүйд тулгуурлан гүйцэтгэж, оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний даалгавар, шалгалтын тестийн санд дүн шинжилгээ хийж боловсруулах
- Багш нарын боловсруулсан тест, шалгалтын даалгавруудад сорилын баталгаат чанарын үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлж туршин хэрэгжүүлэх
- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг үнэлгээний арга зүйг боловсруулж, чанарын үнэлгээ хийн тасралтгүй сайжруулдаг, үнэлдэг байхад сургалтын үйл ажиллагаа хариуцсан албад, нэгж, тэнхим, багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн ажиллах

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

#### **2- р шалгуурын дүгнэлт:**

- “Солонгос хэлний орчуулга” бакалаврын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь суралцагчийн эзэмшвэл зохих МЧХ-ыг тодорхойлж цогц чадамжид суурилсан, үр дүнд чиглэсэн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулгыг тодорхойлж, сургалтын шинэчлэлийг тасралтгүй хийсээр ирсэн. Суралцахуйн үр дүнгийн матриц боловсруулсан, сургалтын нэгдсэн төлөвлөгөөг суралцагч, ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгаа болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр, тушаалын дагуу шинэчлэн өөрчилж, хэрэгжүүлдэг. Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график гарган ажилладаг.

- 2018 онд шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий арга зүйг CDIO байхаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа бөгөөд ОУУБИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий Хорооны 2017.10.04-ний өдрийн шийдвэрээр “Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах загвар”-ыг баталж, зөвлөмж болгон гаргасан хэдий ч сургалтын арга зүйн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээний талаар багш, тэнхэм, албадын ойлголт дутмаг байгаа тул үүнд анхаарч ажиллах хэрэгцээ, шаардлага байна.
- Оюутнууд суралцах явцдаа явцын болон төгсөлтийн шалгалт болон, солонгос хэлний түвшин тогтоох шалгалт (ТОPIK 1,2) өгдөг ба 2014-2015 оноос сурлагын амжилт, чанарын судалгаанд дүн шинжилгээ хийж, үнэлэн ажилладаг сайн туршлага бий болсон хэдий ч суралцагчийн эзэмшвэл зохих МЧХ-ыг үнэлж буй үнэлгээний арга зүйн судалгаа харагдахгүй, оюутнаас авч буй шалгалтын, тестийн боловсруулалт, гүйцэтгэлд баталгаат чанарын үнэлгээ хийсэн байдал болон хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ харагдахгүй байна.

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл/Туршлага:

- 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд сургалтын орчинг сайжруулах заалтууд тусган хэрэгжүүлж байна.
- 1оюутанд ногдох талбай хангалттай, сургалтын тоног төхөөрөмжийн хангалт харьцангуй сайн.

##### Анхаарах асуудал:

- Анги танхим, сургалтын орчин, лабораторийн ашиглалтын талаар суралцагчаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч байх
- Сургалтын тоног төхөөрөмж сайтай ч ашиглалтыг сайжруулах

##### Зөвлөмж:

- Интернэтийн хурд гэх мэт технологийн орчинг сайжруулах, техник технологийн дэвшлийг бүрэн ашиглах

#### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Солонгос хэлний анхан, дунд шатанд гадаадын сургуультай хамтарсан Интерактив хичээлийг тасралтгүй 11 жил ашиглаж байна.
- Үндсэн сурах бичиг, нөөцийн жагсаалт гаргасан. Сургалтын хэрэглэгдэхүүн хүртээмж сайтай.

**Анхаарах асуудал:**

- Сургалт судалгааны програм хангамж, хичээлийн хэрэгслэл, сургалтын хэрэглэгдэхүүний талаар сэтгэл ханамжийн судалгаа байхгүй. Асуулгад энэ талаар байхгүй.

**Зөвлөмж:**

- Суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авч байх.
- Багш нар өөрийн зааж буй хичээл, хөтөлбөрт тохирсон Е-контент, Е-хичээл боловсруулж сургалтад нэвтрүүлэх тал дээр анхаарах.

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Солонгосын парламентын номын сантай холбогдсон нь багш, суралцагчдад эрдэм шинжилгээний ажил хийхэд том боломжоор хангасан байна.
- Номын санд харааны бэрхшээлтэй суралцагсдад зориулсан үсэг томруулагч төхөөрөмж 2-ийг суурилуулсан.
- Номын каталог цахим хэлбэрт орсон, оюутнууд цахимаар хайлт хийж номын сангаар үйлчлүүлэх боломжтой.

**Анхаарах асуудал:**

- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалт хангалттай биш байдаг. Тухайлбал парламентийн номын сан ашигласан мэдээлэл, судалгаа гаргаж байх.

**Зөвлөмж:**

- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа тогтмол гаргах.
- Тайланд бодит мэдээлэл оруулах.

### 3- р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: бүрэн хангасан

#### 3-р шалгуурын дүгнэлт:

- Мастер төлөвлөгөөнд сургалтын орчин сайжруулах заалт тусгаж хичээлийн 2-р байр барьж ашиглалтад оруулсан нь суралцагчдад сурах таатай орчин бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөрт зориулсан технологийн дэвшил бүхий Смарт анги ашиглалтад оруулсан, зайн сургалтын лаборатори ангийн техникийн хүчин чадлыг шинэчилсэн, сургалтын лиценз бүхий Интерактив программ ашиглаж байгаа зэрэг нь сургалтын үйл ажиллагаа үр дүнтэй болоход нөлөөлсөн.
- Стандарт шаардлага хангасан номын сантай, суралцагсдад шаардлагатай ном сурах бичиг, эрдэм шинжилгээний фонд хангалттай, харааны бэрхшээлтэй суралцагсдад зориулсан нэмэлт төхөөрөмж суурилуулсан, мөн хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим суралцагсдын сонсох, харах ой тогтоолтод нөлөөлөх сургалтын үзүүлэн таниулах материал, аудио, видео хэрэглэгдэхүүнтэй, солонгос хэл дээрх сургалтын нэмэлт материалын хүртээмж сайн байгаа нь оюутан сургалтын хэрэглэгдэхүүнээр сайн хангагдсан гэж дүгнэж болно.
- Монголын номын сангийн концерциумын шугамаар олон улсын сайтуудаас эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүл, ном хэвлэл үнэ төлбөргүй үзэх эрхтэй, Солонгосын парламентын номын сантай холбогдсон нь багш, суралцагчдыг эрдэм шинжилгээний ажил хийх том боломжоор хангасан.

#### Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

##### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, тэнхимийн төлөвлөгөө гаргадаг, үүнийгээ тэнхимийн хурлаар хэлэлцүүлж, хэрэгжүүлж үнэлж байгаа байдал тогтмолжиж байгаа нь харагдлаа.
- Улирал бүр оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч судалгааны үр дүнгээр тэнхимийн үйл ажиллагааг үнэлж хэвшсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийдэг.
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт сайн.

**Анхаарах зүйл:**

- Хөтөлбөрийн талаарх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө бий ч төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, сайжруулалт тайланд тусгагдаагүй нотолгоо дутмаг.

**Зөвлөмж:**

- Урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийдэг байх.

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 22 төрлийн оюутны тэтгэлэг хэрэгжүүлж байгаа, оюутан солилцоогоор БНСУ-д очиж сурдаг.
- Жилд 1-2 удаа БНСУ-аас мэргэжилтэн урьж багш нартаа лекц семинар уншуулдаг.

- Оюутан нийгэмд үзүүлсэн сайн дурын үйлсээрээ 30 хүртэл хувийн тэтгэлэг авах боломж бүрдсэн.

**Зөвлөмж:**

- Хамтран хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа, хэрэгжилт, ашиглалтад дүн шинжилгээ хийдэг байх

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Эрдэм шинжилгээний ажил хийхэд багш нарт олгох дэмжлэгийг нэмэгдүүлж байгаа.

**Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ, багш нарын мэргэжил дээшлүүлэх, ном сурах бичгийн сайжруулалтад төсвийн 0.6-0.7 хувийг зарцуулж байна. Сүүлийн жилүүдэд тус хөтөлбөрт эзлэх хувь буурч байгаа хандлагатайг анхаарах

**Зөвлөмж:**

- Сургуулийн зүгээс эрдэм шинжилгээнд зарцуулах төсвийг нэмэгдүүлэх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр сурталчлах үйл ажиллагаа тогтмолжиж хэвшиж байна.

**Анхаарах асуудал:**

- Цаашид хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааг хийж хамрах хүрээг өргөтгөхөд анхаарах

**Зөвлөмж:**

- Цаашид тандан судалгааг өргөн хүрээнд ялангуяа солонгос хэлний орчуулагч болон солонгос хэлтэй ажилтан ажиллуулдаг компаниудыг оролцуулж хийх

- Хөтөлбөрийн маркетинг идэвхжүүлэхийн тулд орчуулагч мэргэжлийн олон улсын чиг хандлагыг харгалзан дотоодын их дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах
- Төгсөгчдийг ажлын байрны шаардлагад нийцүүлэх, бэлтгэх, нийгэмд үйлчлэх хүрээнд “интэншип” тогтолцоог хэрэгжүүлэх боломжийг судлах

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Цахим мэдээлэл болон сэтгүүл, гарын авлагаар дамжуулан мэдээлэл түгээдэг
- Вэбсайтыг тогтмол сайжруулж шинэчилдэг, хандалтын тоог судалдаг

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээг сайжруулахын тулд хөтөлбөрийн хорооны журмыг баталсан. Тэнхим болох дэд хороо нь хөтөлбөр боловсруулах, сайжруулахад тэнхимийн багш нар, ажил олгогчид, төгсөгчид, суралцагчдын төлөөллийн санал бодлыг тусгаж ажилладаг. Хөтөлбөрийн ерөнхий хороо нь хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хөтөлбөр боловсруулалтад хяналт тавьна.
- Хөтөлбөрийн зорилго зорилтын дагуу тэнхимийн ажлын төлөвлөгөө боловсруулж багш бүр сургалт, эрдэм шинжилгээ нийгмийн үйлчилгээний ажлыг тусгасан төлөвлөгөө гаргаж, тэнхимийн хурлаар баталгаажуулж үр дүнг жилийн төгсгөлд тэнхимийн эрхлэгч, сургалтын хяналтын албаны хяналтан дор үнэлж дүгнэдэг. 2014оноос суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч хэвшүүлж байна.
- Хамтын ажиллагаа нийгэмд үйлчлэх хүрээг нэмэгдүүлэхэд анхаарч, 2014оноос хойш БНСУ, ОХУ, БНХАУ, АНУ зэрэг 34 их дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. Сүүлийн 5 жилд 21 оюутан солилцоогоор БНСУ-д явж, 199оюутан тэтгэлэгт хамрагджээ.
- Төгсөгчдийн холбоог 2012 онд байгуулж, жил бүр уулзалт, спортын арга хэмжээг зохион байгуулдаг.
- Хөтөлбөр нь сургуулийн нэгдсэн төсвөөс санхүүждэг, суралцагч багш нарын эрдэм шинжилгээний ажилд нийт төсвийн 0.5 хувийг зарцуулдаг, цаашид төсөв нэмэгдүүлэх шаардлагатай.

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Элсэлтийн бодлого, дүрэм журам



- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаад оюутан элсүүлж сургаж байна.
- Хамтын ажиллагаатай солонгосын их дээд сургуульд оюутан солилцооны хөтөлбөрт олон оюутан хамрагддаг.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага боловсруулан хэвлүүлж, оюутнуудын ашиглалт хангалттай сайн.

#### **Анхаарах асуудал:**

- Элсэлтийн журмын 5 удаагийн шинэчлэлд үр дүнгийн шинжилгээ байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Тайланд элсэлтийн зорилго, зорилт, бодлогыг тодорхой дурьдах.

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тэнхимээс оюутанд зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө жил бүрээр гаргаж, тэнхимийн тайланд тусгаж байна
- Оюутанд чиглэсэн клуб дугуйлан, сургалт, арга хэмжээ, олон нийтийн үйл ажиллагаа сайн зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээг тогтмол, тодорхой гаргаж байх

#### **Зөвлөмж:**

- Суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгаа, бүтээлч байдлыг дэмжиж старт-ап компани байгуулах зэргээр эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх.
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний талаар тайлан гаргаж, дүн шинжилгээ хийдэг байх.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл

- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутнууд чөлөөт цагаараа сайн дурын үйлс хийдэг
- “Нийгмийн үйлчилгээний дэвтэр” хөтөлж, түүн дээр үндэслэн мөнгөн урамшуулал авдаг тогтолцоо хэрэгжүүлсэн.
- Суралцагсдаар сургууль дээр цагийн ажил хийлгэж сургалтын төлбөрийг 30% хөнгөлдөг.

##### **Анхаарах асуудал:**

- Оюутны ЭШХ-д оролцох оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

##### **Зөвлөмж:**

- Сургуулийн, тэнхэмийн судалгааны ажлын чиглэлтэй уялдуулан оюутны ЭШХ-ыг тодорхой сэдвийн дор явуулж байх.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Шилжилт хөдөлгөөний журмын” дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.

##### **Анхаарах асуудал:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний шалтгаан, тоо үзүүлэлтэд хийсэн судалгаа, шинжилгээ байхгүй, цаашид ямар арга хэмжээ авах тухай тодорхойгүй.
- 

##### **Зөвлөмж:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогоо тодорхойлох.

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтэд дотоод хяналт хийж, гарсан зөрчлийн арилгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Оройн ангид суралцагсдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, дүн шинжилгээ хийж байх.

#### **Зөвлөмж:**

- Төгсөлтийн баримт бичгийн загвар гаргаж тайланд хавсаргах.

#### **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **5-р шалгуурын дүгнэлт:**

- Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх талаар уян хатан бодлого явуулж, мэргэжлийн сурталчилгаа, элсэлтийн нээлттэй өдөрлөг зохион байгуулсны үр дүнд хөтөлбөрөөр элсэгч монгол, гадаад оюутны тоо өссөн үзүүлэлттэй. Хамтын ажиллагаатай солонгосын их дээд сургуульд оюутан солилцооны хөтөлбөрт оюутнаа хамруулдаг нь олон улсын түвшинд хүрсэн боловсон хүчин бэлтгэхэд чухал түлхэц болж байна.
- Шинэ элсэгч хүлээн авах өдөрлөг жил бүр зохион байгуулж, алба нэгжүүд сургуулийн дүрэм журам, оюутны эрх үүрэг болон хариуцлагын талаар танилцуулга хийдэг, тэнхим жил бүр оюутанд зөвлөх, оюутныг хөгжүүлэх, үйлчлэх төлөвлөгөө гаргаж, гүйцэтгэлийг тэнхимийн тайланд тусгаж дүгнэж ажилладаг зэрэг нь оюутан сургуулийн амьдралд дасан зохицох, улмаар амжилттай суралцахад дэмжлэг болдог гэж дүгнэж байна.
- “Оюутны алба” оюутанд чиглэсэн бүх үйл ажиллагааг удирдлагаар хангаж, санхүүгээр дэмжин ажилладаг нь суралцагч амжилттай суралцах, амжилттай төгсөхөд сайн нөлөө үзүүлж байна.
- “Нийгмийн үйлчилгээний тэтгэлэг” урамшууллын тогтолцоо нэвтрүүлсэн, дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний тэтгэлэг, хөнгөлөлтөд хамрагдах боломжийг сайн бүрдүүлсэн нь оюутан татах сайн сурталчилгаа болдог төдийгүй оюутанд санхүүгийн дэмжлэг болдог байна.
- Сургуулийн захирлын тушаалаар баталсан “Шилжилт хөдөлгөөний журам”-ын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм, журмын хэрэгжилтэд Дотоод хяналтын газар хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулдаг.

#### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

## **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний зорилго 5-д “сургуулийн хүний нөөцийг хөгжүүлэх, багшийг хөгжүүлэх, ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх” зорилтуудыг тусгасан.
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинг харуулсан судалгааг сүүлийн 5 жилээр гаргасан бөгөөд цаашид тэнхимийн зүгээс докторын судалгааны ажлаа хамгаалах гэж буй багшийг оюутанд чиглэсэн олон нийтийн ажлаас чөлөөлөх, хичээлийн хуваарийн зохицуулалт хийх зэргээр дэмжин ажиллаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхимийн багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, оюутанд чиглэсэн үйл ажиллагааны А, В, С цагийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилээр гарган ажиллаж байгаа ба тэнхимийн зүгээс сургалтын цагийн гүйцэтгэл өндөр байгааг олж харан өдөр, оройн ангийн хичээлийн хуваарьт зохицуулалт хийж ажлын нэг өдрийг бие даалтын өдөр болгон бусад цагийн гүйцэтгэлээ хийх хүсэлтийг шийдвэрлэсэн.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийг харуулсан судалгаа хийсэн.
- Багш нарт олгосон урамшууллын хэрэгжилтийн сүүлийн 5 жилээр гаргаж ажилладаг бөгөөд албан тушаалын зэрэглэлд ажиллаж байгаа багш нарын ажилласан жил, ажлын гүйцэтгэлийн үр дүн, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг харгалзан цалингийн шатлалыг ахиулдаг сайн туршлага хуримтлагдсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- “ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд тодруулбал, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хүний нөөцийг хөгжүүлэх, багшийн ур чадварыг дэмжих болон сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилтуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт гаргах ажил дутмаг байна.

**Зөвлөмж:**

- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа гаргаж, үр дүнд тулгуурлан багшийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд, бодитоор үнэлэхэд анхааран ажиллах

**6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Илрэл нотолгоо:**

-Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт

-Төлөвлөгөө, тайлан

-Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Тэнхимийн зүгээс хичээлийн жил бүр БНСУ-ын их сургуулиудаас нэр хүндтэй багш нарыг урьж туршлага солилцох сургалт зохион байгуулж хэвшсэн.
- Ахмад, залуу багш нарын хамтын ажиллагааг дэмжих, туршлага солилцуулах зорилгоор хичээлийн жилд 2 ба түүнээс дээш удаа нээлттэй хичээл заадаг.
- Багш нарын гадаадад мэргэжил дээшлүүлсэн байдлын судалгааг гарган ажиллаж байгаа.
- 2014 оны “Багшийн хөгжлийн хөтөлбөрт” эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалт, заах арга зүй, гадаад хэлний боловсрол, багшийн өөрийн хөгжил гэсэн чиглэлүүдийг тусган хэрэгжилтийг хангах үүднээс хамтын ажиллагаатай гадаад, дотоодын их, дээд сургуулиудтай хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх, багш нарын бүтээлийг тогтмол хэвлүүлэх, нийт багш нарыг хамарсан сургалт, заах арга зүйн семинарыг зохион байгуулж ажиллаж байгаа ололттой тал, сайн туршлага хуримтлуулан ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- 2014 оны “Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийж нийт багш нарт тайлагнах, хэлэлцүүлэг өрнүүлэн тайлан, дүгнэлт гаргаж ажиллахад анхаарах

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийг хангахад чиглэсэн багшлах болон судалгааны ур чадвар, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, өөрийн хөгжлийг дэмжих хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, үр дүнг тооцоолон ажиллахад сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн албад, нэгж, тэнхимийн хамтын ажиллагааг сайжруулан ажиллах

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентын тоон судалгаа

- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- “ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний зорилго 1-д эрдэм, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, багшийг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоон судалгааг 2014-2018 оны байдлаар гаргасан байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн судалгааг сүүлийн 5 жилээр гаргасан.
- Багш нарын нийтлэгдсэн бүтээлийн судалгааг 2015, 2016, 2017, 2018 оны байдлаар гаргасан.
- Олон улсад нэр хүндтэй сэтгүүлд илтгэл, өгүүлэл хэвлүүлэх, докторын зэрэг хамгаалсан багш нарын тоог нэмэгдүүлэх болон хамтын ажиллагаатай гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах боломж байгааг олж харж байна.
- Эрдэм, шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв, тайланг нэгтгэдэг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын гадаад, дотоодын түншлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоон судалгааг гаргаж, сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2015.10.21-ний хурлаар тэнхимүүдийн судалгааны ажлын чиглэлийг баталсан.

#### **Анхаарах асуудал:**

- “ОУУБИС-ийг 2013-2023 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний зорилго 1-д эрдэм, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх ажлын гүйцэтгэлд хэрэгжилтийн үнэлгээ хийх,
- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоог нэмэгдүүлэхэд үйлийн төлөвлөгөө гарган ажиллах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын эрдэм шинжилгээний судалгааны бүтээлийн ишлэгдсэн байдал дутмаг байгаад анхаарч, мэргэжлийн нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлүүлэхэд анхааран ажиллах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын эрдэм, шинжилгээ судалгааны ажилд зарцуулсан төсвийн гүйцэтгэлээс харахад:
  - 2016 онд 155.309.76 мян.төг зарцуулснаас үндсэн ба нэмэлт цалинд 133.772.60 мян төг, нийгмийн даатгалын шимтгэлд 13.511.03 мян.төг,

ном хэвлэлд – 621.10 мян.төг, эрдэм шинжилгээний ажилд 7.405.03 мян төг зарцуулсан,

- 2017 онд 118.708.51 мян төг зарцуулснаас үндсэн ба нэмэлт цалинд 102.645.42 мян.төг, нийгмийн даатгалын шимтгэлд 10.367.19 мян.төг, ном хэвлэлд 876.50 мян.төг, эрдэм шинжилгээний ажилд 4.819.40 мян.төг зарцуулсан бол,
- 2018 онд 64.139.32 мян.төг зарцуулснаас үндсэн ба нэмэлт цалинд 54.900.20 мян.төг, нийгмийн даатгалын шимтгэлд 6.588.02 мян.төг, ном хэвлэлд 450.00 мян.төг, эрдэм шинжилгээний ажилд 2.201.10 мян.төг тус тус зарцуулсан гэсэн байна. Үүнтэй холбогдуулан багш нарын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах төсвийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах шаардлага гарч байна.

#### **Зөвлөмж:**

- Инноваци, ашигтай загвар, патентийн тоог нэмэгдүүлэхэд богино болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, үнэлэх
- Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, үнэлэх
- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлын эшлэгдсэн байдлыг дэмжихэд чиглэсэн профессорын манлайллыг дэмжин ажиллах
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд гадаад, дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нар хичээлийн жил бүр өөрийн үнэлгээний тайлангаа бичиж, үнэлэлт, дүгнэлт хийж ажилладаг ба багшийн үнэлгээний тайланг үнэлэх дүрэм, журмын талаарх багш нарын ойлголт хангалттай сайн.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авахгүй байгаа сул талаа олж харан цаашид анхаарч ажиллах, багшийн хөгжлийн хөтөлбөрт тусгах тухайгаа дурдсан байна.
- 2011 оноос багшийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг оюутнуудаас авч, үр дүнд тулгуурлан багшийн ажлыг үнэлэх, албан тушаалын зэрэглэл нэмэгдүүлдэгээс гадна Сургалтын албанаас багш бүртэй ганцаарчилсан уулзалт, ярилцлага зохион байгуулдаг.
- Багш бүр өөрийн үйл ажиллагааны тайлан бүхий хавтас бүрдүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн багшлах арга зүйг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын арга зүй эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах
- Гадаадын хамтын ажиллагаатай байгууллагуудад багшийн мэргэжил, заах арга зүй, ур чадвар, судалгааны чадварыг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлуулах бодит боломжоо нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээний асуулгад багшийн сургалт, заах арга зүй, мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх асуулгыг нарийвчлан тусгах, дахин боловсруулалт хийх, оюутны хийж буй хөндлөнгийн үнэлгээний чанарт дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг эрэлхийлэх
- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулах
- Багш нарын ажлын ачаалал их, цалин сүүлийн жилүүддэ нэмэгдээгүй гэх санал, хүсэлтийг харгалзан үзэж цалин, урамшууллын мөнгөн дүнг эргэн харж, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх, энэ нь Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний ажлын байран дээрх сэтгэл ханамжыг нэмэгдүүлэх гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн болохыг нийт удирдлага, хамт олноороо хэлэлцэж, нэгдсэн шийдэлд хүрэх

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **6-р шалгуур дүгнэлт:**

- **ОУУБИС-ийн хувьд “Солонгос хэлний орчуулагч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн сонгон шалгуруулалтыг сургуулийн цахим хуудсаар зарлан, нээлтэй, ил тод, сургуулийн дүрэм журмын дагуу явуулдаг. Багшийн албан тушаалын**



зэрэглэл ахиулах, урамшууллын бодлого ойлгомжтой, энэ талаарх нийт багш нарын ойлголт сайн.

- 2014 онд Багшийн хөгжлийн хөтөлбөрийн батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг хийх шаардлагатай байгаа гэдгээ ойлгож ухаарч байгаа. Туршлага, чадвар, зөв хандлагатай солонгос багш нар ажиллуулж байгаа давуу талаа сурталчлан жил ирэх тусам буур байгаа оюутны элсэлтийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанарыг ахиулахад анхаарч ажиллахаар төлөвлөж байгаа.
- Багшийн сургалтын цаг их байгааг олж харан эрдэм шинжилгээний ажилд зарцуулах цагийг тооцооллыг гарган ажиллах хэрэгтэй бөгөөд эрэм шинжилгээний ажилд зарцуулах төсвийг нэмэгдүүлэхэд анхаарахаас гадна боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгааг ч мөн нэмэгдүүлэн ажиллах шаардлага байна. Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ байгаа хэдий ч энэ нь хөтөлбөрт тусгагдаж, хөтөлбөрийг сайжруулсан, чанаржуулахад хэрхэн чиглэгдэж байна вэ талаар судалгаа, тайлан дутмаг харагдаж байна. Иймд инноваци, ашигтай загвар, патентийн тоог нэмэгдүүлэхэд богино болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, үнэлэх, багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, үнэлэх, бүтээл, судалгааны ажлын эшлэгдсэн байдлыг дэмжихэд чиглэсэн профессорын манлайллыг дэмжин ажиллах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд гадаад, дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах хэрэгцээ, шаардлага байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхэмийн багш нар хичээлийн жил бүр өөрийн үнэлгээний тайлангаа бичиж, үнэлэлт, дүгнэлт хийж ажилладаг ба багшийн үнэлгээний тайланг үнэлэх дүрэм, журмын талаарх багш нарын ойлголт хангалттай сайн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авахгүй байгаа сул талаа олж харан цаашид анхаарч ажиллах, багшийн хөгжлийн хөтөлбөрт тусгах тухайгаа дурьдсан байна. 2011 оноос багшийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг оюутнуудаас авч, үр дүнд тулгуурлан багшийн ажлыг үнэлэх, албан тушаалын зэрэглэл нэмэгдүүлдэгээс гадна Сургалтын албанаас багш бүртэй ганцаарчилсан уулзалт, ярилцлага зохион байгуулдаг. Багш бүр өөрийн үйл ажиллагааны тайлан бүхий хавтас бүрдүүлсэн.

## **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

-Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем

-Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2014 оноос хөтөлбөрийн дэд болон ерөнхий хороо байгуулан ажиллуулж, хөтөлбөрийн бодлого, журам, хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа

**Анхаарах асуудал:**

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн дүн шинжилгээ дутмаг
- Чанарын дотоод баталгаажуулалт хийх удирдлага зохион байгуулалт, албадын ажлын уялдаа холбоо сул

**Зөвлөмж:**

- Чанарын дотоод баталгаажуулалтад дотоодын болон хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, үр дүнг нь хөтөлбөрийн шинэчлэлд тусгадаг байх
- Хөтөлбөрийн чанарын үнэлгээнд дэд хороо, ерөнхий хороо, сургалтын алба, дотоод хяналт зэрэг 4 албаны ажил нэгдмэл байх ёстойг анхаарч, хөтөлбөрийн чанарын үнэлгээ хийхэд эдгээр 4 албадын ажлын уялдааг сайжруулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх

**7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

**Илрэл нотолгоо:**

-Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

-Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн

-Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ

-Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/

-Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлын судалгааг жил бүр авч хэвшсэн байна.
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, төгсөгч ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийж байна.

- Ажил олгогчдоос санал авч тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлж ур чадвар олгодог .

#### **Анхаарах асуудал:**

- Цаашид төгсөгчдөөс авах судалгааг нийт төгсөгчдийн дийлэнх хувийг хамруулахад анхаарах

#### **Зөвлөмж:**

- Төгсөгч, ажил олгогчдын судалгааны асуулгад хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой асуулгыг оруулж, тухайн нөхцөл байдалд тохируулан асуулгыг шинэчилдэг байх.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

-Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/

-Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.

-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Анх удаа магадлан итгэмжлүүлж байгаа ба цаашид олон улсын магадлан итгэмжлэлд орох төлөвлөгөөтэй. Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагуудын талаар анхан шатны судалгаа хийгдсэн.

#### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

- Хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороо нь чанарын үнэлгээ, баталгаажилтыг хариуцан ажиллаж байгаа, улирал бүр батлах шалгалт авдаг, үр дүнг багшийн болон тэнхимийн үнэлгээнд тусгадаг, 2 жил тутамд суралцагчдаас солонгос хэлний түвшин тогтоох шалгалт авч түвшинг тогтоон анализ хийх зэргээр ажилладаг ч хөндлөнгийн үнэлгээ хийлгэж үр дүнг тооцсон баримт нотолгоо дутмаг байна.
- Ажил эрхлэлтийн судалгааг сүүлийн 5 жилд жил бүр авч дүн шинжилгээ хийж тогтмолжуулж байна. Мөн хөтөлбөрийн үр дүнг тооцоолохын тулд төгсөгчдийн эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад судалгаа хийхэд ажил олгогчдын 67% нь бүрэн нийцдэг, 33% ихэвчлэн нийцдэг гэсэн үнэлгээ авсан байна.

**ДҮГНЭЛТ**

ОУУБИС-ийн Гадаад хэлний орчуулга ( Солонгос хэл) хөтөлбөрийг 7 шалгуураар магадлан шинжиллээ. Тус сургууль нь уг хөтөлбөрийг 23 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, зорилго зорилтыг тодорхойлж, сургуулийн алсын хараа, зорилгод нийцүүлэн суралцагчдад мэдлэг, чадвар, хандлагыг олгож байна.

Шинжээчдийн баг 7 шалгуур тус бүрээр өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримттай танилцаад 6 шалгуурыг бүрэн хангасан, 1 шалгуурыг хэсэгчлэн хангасан гэж үзлээ. Хөтөлбөрийн төлөвлөлт, хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтын хувьд системтэй төлөвлөлт, арга барил төлөвшсөн, энэ чиглэлээр авч буй арга хэмжээ үйл ажиллагаа сайн хэрэгжиж, гүйцэтгэлийн түвшин сайжирч байна. Хөтөлбөрийг сайжруулах зорилгоор зах зээлийн болон ижил төстэй хөтөлбөртэй харьцуулалт шинжилгээ, үнэлгээ хийж байгаа. Ажил олгогч, төгсөгчдийн эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны үр дүнг ашиглаж эхэлж байна. Хөтөлбөрийн чанарын үнэлгээнд анхаарч, дотоод баталгаажуулалт хийж эхэлсэн ч хөндлөнгийн үнэлгээ хийж хөтөлбөрөө сайжруулах шаардлага бий гэж үзлээ. Суралцагчид чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, тэтгэлэгийн олон төрлийн тогтолцоог бүрдүүлсэн, гадаадын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг, оюутан солилцоо хийж байгаа, стандарт шаардлага хангасан номын сан, суралцагсдад шаардлагатай ном сурах бичиг, эрдэм шинжилгээний фонд, интерактив болон смарт ангитай зэргээр сургалтын орчныг сайжруулж байгаа давуу талууд олон байна. Иймээс 6 шалгуурын шаардлагыг бүрэн хангасан гэж шинжээчдийн баг үзлээ.

Гагцхүү 2-р шалгуурын хувьд “Солонгос хэлний орчуулга” бакалаврын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь суралцагчийн эзэмшвэл зохих МЧХ-ыг тодорхойлж цогц чадамжид суурилсан, үр дүнд чиглэсэн хөтөлбөрийн төлөвлөлт, агуулгыг тодорхойлж, сургалтын шинэчлэлийг тасралтгүй хийсээр ирсэн, суралцахуйн үр дүнгийн матриц боловсруулсан, сургалтын нэгдсэн төлөвлөгөөг суралцагч, ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгаа болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын шийдвэр, тушаалын дагуу шинэчлэн өөрчилж, хэрэгжүүлдэг давуу тал байгаа ч 2018 онд шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий арга зүйг CDIO байхаар төлөвлөж, хэрэгжүүлэхдээ сургалтын арга зүйн хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээний талаар багш, тэнхэм, албадын ойлголт дутмаг, суралцагчийн эзэмшвэл зохих МЧХ-ыг үнэлж буй үнэлгээний арга зүйн судалгаа харагдахгүй, оюутнаас авч буй шалгалтын, тестийн боловсруулалт, гүйцэтгэлд

баталгаат чанарын үнэлгээ хийсэн байдал болон хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ тайланд болон илрэл нотолгоогоор дутмаг байсан зэрэг шалтгаанаар хэсэгчилсэн хангасан гэж үзлээ.

Шалгуур тус бүрийн үнэлгээг шалгууруудын хэсэгчилсэн хангасан үнэлгээний үндэслэлийн хамт хүснэгтээр харууллаа.

№	Шалгуур	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй	Үндэслэл
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан	2	1	0	1.3. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга зүй тодорхой бус, хичээлийн хөтөлбөрт CDIO-ийн холбоо хамаарал дутмаг
2	Сургалтын үйл ажиллагаа	Хэсэгчлэн хангасан	1	2	0	2.2, 2.3. Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжыг олгоход чиглэгдсэн байхаар төлөвлөгдсөн, сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж, зааварчилгааг боловсруулсан, суралцагчийн сурлагын амжилт, чанарын үнэлгээг хийж хэвшсэн хэдий ч хэрэгжилтийн болон чанарын баталгаажуулалтын үнэлгээг хийдэг байдал дутмаг, суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж буй үнэлгээний арга зүйн судалгаа өөрийн үнэлгээний тайлан болон багш нарын хөтөлбөрт хийж буй дүн шинжилгээ, хөтөлбөрийн хавтас зэрэгт харагдахгүй байна.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Бүрэн хангасан	3	0	0	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Бүрэн хангасан	5	0	0	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Бүрэн хангасан	5	0	0	

6	Багшийн үйл ажиллагаа	Бүрэн хангасан	3	1	0	6 . 3 Багшийн сургалтын цаг их байгааг олж харан эрдэм шинжилгээний ажилд зарцуулах цагийг тооцооллыг гарган ажиллах хэрэгтэй бөгөөд эрэм шинжилгээний ажилд зарцуулах төсвийг нэмэгдүүлэхэд анхаарахаас гадна боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, <del>Башигтайрвагвар</del> <del>рэгжүүнсийн төсөн</del> <del>кудэлбар</del> , судалгааны ажлын дүлэн <del>андээлхбайрцлахад</del> <del>бийнэн</del> энэ нь хөтөлбөрт тусгагдаж, хөтөлбөрийг сайжруулсан, чанаржуулахад хэрхэн чиглэгдэж байна вэ талаар судалгаа, тайлан дутмаг харагдаж байна.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	Бүрэн хангасан	2	1	0	7.1 Чанарын дотоод баталгаажуулалтад дотоодын болон хөндлөнгийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээний нотолгоо баримт дутмаг, албадын хоорондын хамтын ажиллагаа ажлын уялдаа сул
6 шалгуур-бүрэн хангасан						
1 шалгуур-хэсэгчлэн хангасан						

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

ОУУБИС-ийн Гадаад хэл орчуулга (Солонгос хэл)-ний хөтөлбөрийг магадлан, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга зүйг боловсруулж хэрэглэх, сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгааг Блум таксономи, Marzano таксономи, Рубрик арга зэрэг үнэлгээний арга зүйд тулгуурлан гүйцэтгэж, оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний даалгавар, шалгалтын тестийн санд дүн шинжилгээ хийж боловсруулах, хичээлийн хөтөлбөрт CDIO-ийн холбоо хамаарлыг уялдуулах
- Суралцахуйн үр дүнгийн матрицыг нэгж хичээлийн мэдлэг, чадвар, хандлага гэж томъёолсон тохиолдолд үр дүнгээ үнэлэх боломжыг хэрхэн харж байгаа талаар дүн шинжилгээ хийх
- Багш нарын боловсруулсан тест, шалгалтын даалгавруудад сорилын баталгаат чанарын үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлж туршин хэрэгжүүлэх

- Хичээл хоорондын залгамж холбоог харуулахдаа дан хичээлүүдийн код биш нэрсийг бичиж графикийг сайжруулах
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтуудыг хийхдээ оюутан хичээл заах багшийн туршлага, арга зүй, хичээлийн хэлбэр, зохион байгуулалтын онцлог зэрэг мэдээллийг танилцуулга хэлбэрээр оюутанд нээлттэй хүргэж сонгуулдаг байхад чиглэн ажиллах
- “Бакалаврын сургалтын хөтөлбөр боловсруулах загвар” буюу зөвлөмжийн хүртээмжтэй байдалд анхаарч, нийт багш нарын дунд хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, сургалтын ерөнхий арга зүй болох CDIO-г хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох төлөвлөгөөт үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаа хариуцсан албад, тэнхимтэй хамтран хэрэгжүүлж, үнэлгээ хийх
- Багш нар өөрийн зааж буй хичээл, хөтөлбөрт тохирсон E-контент, E-хичээл боловсруулж сургалтад нэвтрүүлэх тал дээр анхаарах.
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа тогтмол гаргах.
- Сургуулийн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийдэг байх.
- Суралцагчид багш нарын эрдэм шинжилгээ, судалгаа, бүтээлч байдлыг дэмжиж старт-ап компани байгуулах зэргээр эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх, гадаад, дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах зэргээр эрдэм шинжилгээнд зарцуулах төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогоо тодорхойлох.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа гаргаж, үр дүнд тулгуурлан багшийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, бодитоор үнэлэх, багшийн хөгжлийг дэмжиж үр дүнг тооцоолон ажиллахад сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн албад, нэгж, тэнхимийн хамтын ажиллагааг сайжруулан ажиллах
- Инноваци, ашигтай загвар, патентийн тоог нэмэгдүүлэхэд богино болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, үнэлэх, багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, үнэлэх, хамтран хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа, хэрэгжилт, ашиглалтад дүн шинжилгээ хийдэг байх
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны асуулгад технологийн орчинг сайжруулах талаар, багшийн сургалт, заах арга зүй, мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх талаар асуулгыг нарийвчлан тусгах, дахин боловсруулалт

хийх, оюутны хийж буй хөндлөнгийн үнэлгээний чанарт дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замыг эрэлхийлэх

- Суралцагчийн цагийн ачааллын судалгааг курс бүрээр гаргаж, бие даалтын ажилд зарцуулах цагийн судалгаа хийн нарийвчлан тусгаж өгөх
- Чанарын дотоод баталгаажуулалтад дотоодын болон хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, үр дүнг нь хөтөлбөрийн шинэчлэлд тусгадаг байх
- Төгсөгч, ажил олгогчдын судалгааны асуулгад хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой асуулгыг оруулж, тухайн нөхцөл байдалд тохируулан асуулгыг шинэчилж, үр дүнгийн шинжилгээ хийж, сайжруулалтад тусгадаг байх
- Цаашид хөтөлбөрөөр төгсөж буй мэргэжилтний хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагыг олон улсын чиг хандлагыг харгалзаж тооцоолох шаардлагатай.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Олон улсын Улаанбаатарын их сургуулийн “ Гадаад хэлний орчуулагч (солонгос хэл)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн үнэлгээ дүгнэлтийг Урлаг хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... Д. Эрдэнэсүрэн

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Н. Мэнд

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Г. Энхжаргал

#### IV. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

##### I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Кан Соньхуа	ахлах багш	Ph.D		Ярих сонсох 1-6
2	Г. Баярмаа	ахлах багш	Ph.D		Солонгос хэлний онол, орчуулга
3	Д. Болормаа	Дэд проф	Ph.D		Орон судлал
4	Э. Баярмаа	ахлах багш	магистр		Ханз, УБД
5	С. Энхзул	ахлах багш	магистр		Интерактив, УБД



6	Б. Болормаа	ахлах багш	магистр		Интерактив, УБД
7	Ким Ынжон	ахлах багш	магистр		ЯСД, найруулга зүй
8	Г. Эрдэнэчимэг	Багш	магистр		орчуулга
9	Х. Уянга	Багш	магистр		Хэлмэрчлэхүй, УБД
10	Ан Жунбуг	Багш	магистр		ЯСД
11	С. Энх-Амгалан	Багш	магистр		Интерактив, УБД
12	М. Амартайван	Багш	магистр		Уран зохиол
13	Ким Жунуг	Багш	магистр		ЯСД

## II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Гарын үсэг
1	Ц. Болортуяа	СХО4	Голч өндөр	
2	Э. Номин-Эрдэнэ	СХО4	Голч өндөр	
3	Т. Мөнхцэцэг	СХО4	Орон нутгийнх	
4	Мөнхзаяа	СХО4	Орон нутгийнх	
5	Хишигдалай	Оройн 2		
6	Мөнхтулга	СХО3	Дотуур байрны	
7	Хонгорзул	СХО3	ОЗ-ийн гишүүн	
8	Хэрлэн	СХО3	Орон нутгийнх	
9	Ган-Эрдэнэ	СХО3	Голч өндөр	
10	Нямжаргал	СХО2а	Орон нутгийнх	
11	Г. Намуун	СХО2а	Голч өндөр	
12	Бэртэ	СХО2а	Орон нутгийнх	
13	Энэрэл	СХО2а	Голч өндөр	
14	Ихэрцэцэг	СХО2б	Сайн дурын байгууллагын гишүүн	
15	Б. Цэнджав	СХО2б	Дотуур байрны	
16	А. Болормаа	СХО2б	Голч өндөр	
17	Сарантуяа	СХО2б	Голч өндөр	
18	Д. Халиун	СХО1а	Голч өндөр	
19	О. Хулан	СХО1а	Орон нутгийнх	
20	Отгонсувд	СХО1а	Сайн дурын байгууллагын гишүүн	
21	Мөнхтунгалаг	СХО1а	Голч өндөр	
22	Олчей	СХО1б	Гадаад оюутан	
23	Диана	СХО1б	Гадаад оюутан	
24	Энхцэцэг	СХО1б	Хөгжлийн бэрхшээлтэй	
25	Саран	СХО1б	Гадаад оюутан	

## III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Хонгорзул	Сургууль зуучлал	Захирал	88553530	
2	Ду ХёнЮун	сүм	пастор	91991127	
3	Ким Хынсан	ЭСЯ	ажилтан	94110012	
4	КимВонсоб	Сургалтын төв	захирал	83081010	
5	КвонУсог	23р сургууль	багш	91193522	
6	Мөнхнасан	Сүлд хүү ХХК	захирал	88209969	

#### IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэрс	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал	Утас	Гарын үсэг
1	Б. Ундрах	2018	Good people ТББ	Оффис хариуцагч	91130050	
2	Б. Хосчимэг	2018	Сант-Оюу ХХК	орчуулагч	90585568	
3	Түвшин	2006	Хаан банк	мэргэжилтэн	99008146	
4	Ундармаа	2004	Хаан банк, тооцооны төв	захирал	91991118	
5	Энхжаргал	2008	Хаан тревел	хөтөч	88807473	
6	П. Мөнгөнтуяа	2016	Samsung C&TSCRECM LLC	ажилтан	91658011	
7	Б. Саран-Отгон	2007	Хүрээ бүрэн дунд сургууль	багш	99822874	
8	Т. Мөнхжаргал	1998	ШУТИС-	багш	99233597	
9	Б. Батцэцэг	2018	Койка	ресепшн	80588890	

#### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН  
ИХ СУРГУУЛЬ**

210644 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14,  
Намынхүгийн гудамж, Утас: 462026-7 Факс: (976-11)462040  
www.ubu.edu.mn, E-mail: iubu@ubu.edu.mn

2019.03.26 № 1/148

танай \_\_\_\_\_ (-ны, -ний) № \_\_\_\_\_ -т

Гадаад хэлний орчуулга (Солонгос хэл)  
хөтөлбөрийн шинжээчийн өөрийн үнэлгээний  
тайланд хариу хүргүүлэх тухай

ОУУБИС-ийн Гадаад хэлний орчуулга (Солонгос хэл) хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг хүлээн авч, Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны захирлын 2019 оны 02 сарын 26-ны өдрийн 35 дугаар тушаалаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх багийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон 2019 оны 03 сарын 12-13-ны өдрүүдэд ажиллуулж, шинжээчийн үнэлгээний тайланг хүргүүлжээ.

Гадаад хэлний орчуулга (Солонгос хэл) хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн багийн “Шинжээчийн үнэлгээний тайлан”-г 2019 оны 03 сарын 25-ны өдөр хүлээн авч, ОУУБИС-ийн “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний комисс” хуралдан танилцаж, шинжээчдээс ирүүлсэн шалгуур бүрийн дүгнэлт, зөвлөмжид ямар нэгэн санал, гомдол байхгүй бөгөөд ойрын ирээдүйд анхаарах асуудлуудыг сайжруулан гүйцэтгэх чиглэлээр ажиллана хэмээн үзэж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



НАМГИ ЁН

## ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

## ҮІІ. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо).....

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

## ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Шалгуур		Үнэлгээний ерөнхий хүчин зүйл			
		Төлөвлөлт/Хандлага	Хэрэгжилт/Үр дүн	Үнэлгээ/Дүгнэлт	Сайжруулалт/Хөгжүүлэлт
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>Тухайн үйл явцын төлөвлөлт, хандлага, арга барил нь хэр үр дүнтэй байна вэ?</li> <li>Төлөвлөлт, хандлага, арга барил нь эрхэм зорилгын хэрэгжилтэд хэр ач холбогдолтой вэ?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төлөвлөлт, арга барил нь үр дүнтэй хэрэгжиж байна уу? Үнэн бодит тоо, баримт мэдээлэл, давтамж гэх мэт хэмжигдэхүйц үр дүнгүүд нотлогдож байна уу?</li> <li>Хандлага, арга хэлбэр нь бүх нэгж хэсгүүдэд тууштай, харилцан уялдаатай хэрэгжиж байна уу?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гүйцэтгэл болон чанарын үзүүлэлтээр хэрэгжилт, үр дүнг тогтмол үнэлж, дүгнэж байна уу?</li> <li>Хэрэгжилт, үр дүн нь хэрэглэгч, оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцэж байгааг судалж, үнэлж байна уу?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үр дүнгээс суралцаж, үйл явцыг сайжруулж буй байдал</li> <li>Сайжруулах үйл явцаар дамжуулан хандлага, арга хэлбэрийг шинэчилж буй байдал</li> <li>Амжилт, өөрчлөлтийг дэмжиж, урамшуулж буй байдал</li> <li>Ахиц дэвшил, инновацийг бусад нэгжүүд болон үйл явцад түгээн дэлгэрүүлдэг байдал</li> </ul>
2	Сургалтын үйл ажиллагаа				
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл				
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт				
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа				
6	Багшийн үйл ажиллагаа				
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт				
Үнэлгээ		Үнэлгээний ерөнхий дүгнэлт			
Бүрэн хангасан		Үр өгөөжтэй, системтэй төлөвлөлт, хандлага, арга барил төлөвшсөн.	Зарим нэгж, хэсгүүдэд харилцан адилгүй байгаа боловч төлөвлөлт, арга барил нь сайн хэрэгждэг.	Үйл явцыг үнэлэх, сайжруулахад чиглэсэн чанарын үнэлгээний системийг бүрдүүлж эхэлсэн.	Байнгын үнэлгээ, дүн шинжилгээнд тулгуурлан үйл явцын ач холбогдол, үр өгөөжийг сайжруулдаг.
		<ul style="list-style-type: none"> <li>Тухайн шалгуурт хамаарах ихэнх үйл ажиллагаа сайн хэрэгжиж, гүйцэтгэлийн түвшин сайжирч байна.</li> <li>Үйл ажиллагааны үр дүн, үр өгөөжийг сайжруулах зорилгоор харьцуулалт, шинжилгээ, үнэлгээ хийж эхэлсэн.</li> <li>Чухал ач холбогдол бүхий сайжруулалт, өөрчлөлт, шинэчлэл, инноваци хийж эхэлсэн.</li> <li>Зарим үр дүн нь эрхэм зорилго, үндсэн хэрэглэгч, зах зээлийн шаардлагатай уялдаж байна.</li> </ul>			

<b>Хэсэгчлэн хангасан</b>	Үр өгөөжтэй, системтэй төлөвлөлт, хандлага, арга барил төлөвшиж эхэлсэн.	Зарим нэгж, хэсгүүдэд харилцан адилгүй байгаа боловч төлөвлөлт, арга барил нь саадгүй хэрэгжих эхлэлийн шатанд байна.	Асуудлыг тогтоож, сайжруулах чиглэлээр үнэлгээ хийж байна.	Асуудлыг шийдэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч, үйл ажиллагаа сайжирсан.
	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн шалгуурт хамаарах зарим үйл ажиллагаа сайн хэрэгжиж, гүйцэтгэлийн түвшин сайн үзүүлэлттэй болж байна.</li> <li>• Үйл ажиллагааны үр дүн, үр өгөөжийг сайжруулах зорилгоор харьцуулалт, шинжилгээ, үнэлгээ хийж эхэлсэн тухай тайлагнаагүй, мэдээлэл хангалтгүй.</li> <li>• Чухал ач холбогдол бүхий сайжруулалт, өөрчлөлт, шинэчлэл, инноваци хийх тухай тайлагнаагүй, мэдээлэл хангалтгүй.</li> <li>• Шалгуурыг хангаж буйг нотлох маш цөөн үр дүнг тайлагнасан.</li> </ul>			
<b>Хангаагүй</b>	Үр өгөөжтэй, системтэй төлөвлөлт, хандлага, арга барил байгаа нь нотлогдохгүй.	Төлөвлөлт, арга барил нь хэрэгжсэн гэх баримт хангалтгүй.	Үнэлгээ, дүгнэлт хийсэн баримт нотолгоо байхгүй.	Сайжруулах хандлага, өөрчлөлтийг нотлох мэдээлэл хангалтгүй.
	<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн шалгуурт хамаарах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тайлагнаагүй, эсвэл маш муу үр дүнг тайлагнасан.</li> <li>• Үйл ажиллагааны үр дүн, үр өгөөжид сөрөг нөлөө бүхий хандлага, арга барил илэрсэн.</li> <li>• Ахиц дэвшил, сайжруулалтын талаарх мэдээлэл хангалтгүй, эсвэл тайлагнаагүй.</li> <li>• Шалгуурыг хангаж буйг нотлох үр дүнг тайлагнаагүй.</li> </ul>			